“САНСИТ КАПИТАЛ ББСБ” ХХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДЭД

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Санал дүгнэлт

Бид “САНСИТ КАПИТАЛ ББСБ” ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн илчлэл тодруулгад аудитыг хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр “САНСИТ КАПИТАЛ ББСБ” ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого, зардал, үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт, түүнд нийцүүлэн гаргасан Монгол улсад одоо мөрдөж буй журам зааврын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх, эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой гэж бид үзэж байна.

Аудитын гол асуудлууд

Бидний гаргасан тайланд анхаарал хандуулахуйц аудитын гол асуудал байхгүй гэж тодорхойлж байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон аудиторын тайлан багтаагүй байж болно. Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй болно.

Санхүүгийн тайлангийн талаар удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага

Компанийн удирдлага нь СТОУС-ын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаагаа зогсоох, ингэхээс өөр сонголтгүй байхаас бусад тохиолдолд удирдлага санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хүлээх ба тасралтгүй байдалтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлд ашигласан тасралтгүй байдлын суурийн талаар нэмэлт тодруулга хийнэ.

Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Мөн бид дараах ажлуудыг хийсэн:

- ✓ Санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдэлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлүүдэд хариу аудитын горимуудыг тодорхойлж хэрэгжүүлсэн, мөн дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах зэрэг залилангаас шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН
(үргэлжлэл)

- ✓ Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.

- ✓ Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.

- ✓ Хэрэв компанийн тасралтгүй байх чадавхид материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт анхаарлаа хандуулах болно. Хэрэв энэ талаар холбогдох тодруулгад хангалттай дурдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг огноолох өдөр хүртэлх аудитын нотолгоонд суурилна. Иймд компанийн тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсэж болох юм.

- ✓ Санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.

Бид засаглах удирдлагатай аудитын цар хүрээ, хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар харилцсан.

Мөн бид засаглах удирдлагад аудиторын хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудыг мэдэгдсэн бөгөөд бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц аливаа харилцаа холбоо, түүнээс сэргийлэх арга хэмжээнүүд болон бусад асуудлуудын талаар ярилцсан.

Засаглах удирдлагатай харилцсаны үндсэн дээр бид тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитаар хамгийн чухал гэж авч үзсэн асуудлуудыг тодорхойлж аудитын гол асуудлууд гэж үзсэн. Бид олон нийтэд мэдээлэх нь сөрөг үр дагаврыг авчрах учраас хууль тогтоомжоор хориглосон байдаг асуудлаас бусад аудитын асуудлуудыг аудиторын тайландаа харуулсан.

Бусад

Энэхүү тайланг Компанийн тухай хуулийн 94 дүгээр зүйлд заасны дагуу компанийн хувь нийлүүлэгчдэд зориулан бэлтгэсэн ба тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч талын өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.

ЗАХИРАЛ _____ **(С.ДОЛЖИНСҮРЭН)**

"БАЯН СУВАРГА АУДИТ" ХХК
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ УЛС

2023 ОНЫ 03 ДУГААР
САРЫН 30-НЫ ӨДӨР

"САНСИТ КАПИТАЛ ББСБ" ХХК-ИЙН АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон тайлант жил

/мянган төгрөгөөр/

	Тодруулга	2021.12.31	2022.12.31
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	7	1,385,337.8	939,268.1
Богино хугацаат хөрөнгө оруулалт	7	604,235.5	604,235.5
Зээлдэгч нарт олгосон зээл (цэвэр)	7	779,090.5	1,226,830.6
Бусад авлага	7	275,162.0	257,912.3
Бусад хөрөнгө	8	90,403.4	887,803.4
Эргэлтийн хөрөнгийн дүн		**3,134,229.2**	**3,916,049.9**
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө (цэвэр)	8	14,022.6	7,769.2
Биет бус хөрөнгө	8	1,830.9	1,502.2
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		**15,853.6**	**9,271.4**
НИЙТ ХӨРӨНГӨ		**3,150,082.8**	**3,925,321.3**
ӨР ТӨЛБӨР			
Богино хугацаат өр төлбөр			
ААН-ийн орлогын албан татварын өглөг	8	66,807.0	29,669.8
ХХОАТ-ын өглөг	8	592.9	6,315.1
НДШ-ийн өглөг	8		1,991.3
Богино хугацаат өр төлбөрийн дүн		**67,399.9**	**37,976.2**
НИЙТ ӨР ТӨЛБӨР		**67,399.9**	**37,976.2**
Өөрийн хөрөнгө			
Хувь нийлүүлсэн хөрөнгө	9	1,900,000.0	2,500,000.0
Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн		**1,900,000.0**	**2,500,000.0**
Хуримтлагдсан ашиг /алдагдал/	9		
Өмнөх үеийн		894,765.8	1,107,535.4
Тайлангийн үеийн	9	287,917.0	279,809.7
Хуримтлагдсан ашиг /алдагдал/		**1,182,682.9**	**1,387,345.1**
ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		**3,082,682.9**	**3,887,345.1**
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		**3,150,082.8**	**3,925,321.3**

"САНСИТ КАПИТАЛ ББСБ" ХХК-ИЙН АУДИТ ХИЙГДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон тайлант жил

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Тодруулга	2021.12.31	2022.12.31
ХҮҮГИЙН ОРЛОГО			
Зээлийн хүүгийн орлого	10	446,537.8	450,790.5
Банк, санхүүгийн байгууллагаас авсан хүүгийн орлого	10		9,179.9
Хүүгийн орлогын дүн		**446,537.8**	**459,970.4**
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ОРЛОГО			
Үйлчилгээний шимтгэл	12	450.5	1,068.6
Санхүүгийн бусад ажил, үйлчилгээний орлого	12	444.7	
Үйл ажиллагааны бусад орлогын дүн		**895.2**	**1,068.6**
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ОРЛОГО		**447,433.0**	**461,039.0**
Эрсдэлийн зардал		48,468.0	20,701.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР ОРЛОГО		**398,965.0**	**440,337.9**
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ			
Ажилтнуудын цалингийн зардал	13	35,553.8	74,724.1
Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	13	5,061.1	9,819.3
Боловсон хүчний бусад зардал	13	6,484.9	443.5
Зээл авлагыг барагдуулахтай холбоотой зардал	13		8,165.7
Зохицуулалтын үйлчилгээний хөлс	13	3,000.0	3,088.3
Хөндлөнгийн хяналтын зардал	13	750.0	600.0
Элэгдэл хорогдлын зардал	13	8,649.2	7,398.9
Түрээсийн зардал	13	10,069.0	13,056.0
Бичиг хэргийн зардал	13	257.4	349.6
Шуудан холбооны зардал	13	1,509.6	1,999.2
Шатахуун, тээврийн хэрэгслийн зардал	13	1,686.9	1,446.4
Сэлбэг хэрэгсэл засвар үйлчилгээний зардал	13	1,449.6	3,629.9
Даатгалын зардал	13		
Үл хөдрөх хөрөнгийн татвар	13	331.6	569.6
Зар сурталчилгаа, маркетингийн зардал	13	100.0	223.9
Үйл ажиллагааны бусад зардал	13	6,389.9	7,760.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	**13**	**81,293.0**	**133,274.7**
Бусад олз (гарз)	14	**2,012.2**	**2,416.3**
ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ ОРЛОГО /АЛДАГДАЛ/		**319,684.2**	**309,479.5**
Орлогын татварын зардал	14	31,767.2	29,669.8
ЦЭВЭР ОРЛОГО /АЛДАГДАЛ/		**287,917.0**	**279,809.7**

"САНСИТ КАПИТАЛ ББСБ" ХХК-ИЙН АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон тайлант жил

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Дахин үнэлгээний нөөц	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Хуримтлагд-сан ашиг	Нийт дүн
2020 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	1,900,000.0			894,765.8	**2,794,765.8**
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
Залруулсан үлдэгдэл					
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй цэвэр олз, гарз					
Нэмж оруулсан хөрөнгийн өөрчлөлт					-
Тайлант үеийн цэвэр ашиг				287,917.0	**287,917.0**
Хуваарилсан ногдол ашиг					-
Хувьцаат капиталын өсөлт					
2021 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	**1,900,000.0**			**1,182,682.9**	**3,082,682.9**
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
Залруулсан үлдэгдэл					
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй цэвэр олз, гарз				35,963.7	**35,963.7**
Нэмж оруулсан хөрөнгийн өөрчлөлт	600,000.0				**600,000.0**
Тайлант үеийн цэвэр ашиг				279,809.7	**279,809.7**
Хуваарилсан ногдол ашиг				111,111.1	**111,111.1**
Хувьцаат капиталын өсөлт					
2022 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	**2,500,000.0**		-	**1,387,345.2**	**3,887,345.2**

"САНСИТ КАПИТАЛ ББСБ" ХХК-ИЙН АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон тайлант жил

/мянган төгрөгөөр/

	2021.12.31	2022.12.31
1. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	**(76,979.3)**	**(946,008.4)**
1.1 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	**406,966.0**	**476,034.4**
1.1.1. Зээлийн хүүгийн орлого	406,515.5	465,785.9
1.1.4. Харилцах дансны хүүгийн орлого	-	9,179.9
1.1.16. Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	450.5	1,068.6
1.1.18. Бусад үйлчилгээний орлого		
1.2 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	**483,945.3**	**1,422,042.8**
1.2.1. Үндсэн ба нэмэгдэл цалин	29,231.9	60,807.6
1.2.2. Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал	8,962.1	16,421.3
1.2.3. Ашиглалтын зардалд төлсөн мөнгө		
1.2.4. Шатахуун, холбоо, интернет, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,344.0	7,075.5
1.2.5. Бичиг хэргийн зардал, ариун цэврийн зардал	356.4	503.3
1.2.6. Татвар, даатгалын төлсөн мөнгө	4,025.3	43,229.6
1.2.7. Зар сурталчилгаанд төлсөн мөнгө	100.0	223.9
1.2.8. Зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбогдон гарсан мөнгө		8,165.7
1.2.9. Аудитын төлбөр, мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээнд төлсөн	750.0	600.0
1.2.10. Зохицуулалтын үйлчилгээний хураамжид төлсөн	3,000.0	3,088.3
1.2.11. Ногдол ашгаар олгосон мөнгө		1,079,307.2
1.2.12. Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө	433,175.6	202,620.4
2. ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		**499,938.7**
2.1. Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого		501,123.6
2.2. Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлага		1,184.9
2.2.1. Баяр ёслол, зочин төлөөлөгчийн зардал		577.7
2.2.3. Бусад		607.2
3. БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	**(76,979.3)**	**(446,069.7)**
4.1. МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	**1,462,317.2**	**1,385,337.8**
4.2. МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	**1,385,337.8**	**939,268.1**

Аудитын тайлан, тодруулгыг монгол хэлээр 2 хувь бэлтгэсэн бөгөөд хуулбарт утгын зөрүү гарвал эх хувийг баримтлах болно.

БАЯНСУВАРГА АУДИТ ХХК
УЛААНБААТАР ХОТ

(С.ДОЛЖИНСҮРЭН)

"БАЯН СУВАРГА АУДИТ" ХХК
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ УЛС

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР